

12  
2017

VOL. 147

*Living the Lotus-Buddhism in Everyday life*, conveys our hope of striving to practice the teachings of the Lotus Sutra in daily life in an imperfect world to enrich and make our lives more worthwhile, like beautiful lotus flowers blooming in a muddy pond. This newsletter aims to help people around the world apply Buddhism more easily in their daily lives.

### “Хэлбэр”-ийг сурах

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### “Хэлбэр” бол уран арга

Жүүдо, кэндо зэргийн спорт, мөн урлаг, уран сайхны ертөнцөд биеэ авч явах байдал ба үйл хөдлөлийн үндсэн “хэлбэр” гэж байдаг. Зөвхөн урлаг, спорт төдийгүй бидэнд ч гэсэн өдөр тутамдаа биеэ авч явах “хэлбэр” байдаг гэж би боддог.

Жишээлбэл цаг барих, өглөө босоод “өглөөний мэнд” гэж гэрийнхэнтэйгээ мэндлэх, тайлсан гутлаа зэрэгцүүлж тавих, хүн дуудвал хариу хэлэх зэрэг “хэлбэр”-ийг хэвшил болгож, өдөр бүр хэрэгжүүлэх чухал.

Үйл хөдлөл гэдэг нь “бие, үг хэл, сэтгэлийн илрэл” юм. Өөрөөр хэлбэл бид үйл хөдлөл, үг хэлээр дамжуулж сэтгэлээ илэрхийлдэг.

Тэгвэл тэр сэтгэл гэдэг нь юу юм бол? Сэтгэлийн ямар “хэлбэр”-ийг хэвшил болгох чухал юм бол? Хариултыг нь түрүүлээд хэлбэл энэрэнгүй нинжин сэтгэл юм. Энэрэнгүй нинжин сэтгэлийг хөгжүүлэхийн тулд энэрэнгүй сэтгэлээ биеэрээ илэрхийлж, тэр “хэлбэр”-ээ хэвшил болгож, өдөр бүр хэрэгжүүлэх хэрэгтэй.

Бурханы сургаалыг хэрэгжүүлдэг бидний хувьд алга хавсран мөргөх ба өглөө орой судар унших үйл нь амьдралын чухал “хэлбэр”-ийн нэг болох юм. Энэ ч гэсэн энэрэнгүй, талархсан сэтгэлээ биеэрээ илэрхийлж байгаа хэрэг ба “үргэлж ийм сэтгэлтэй байх”-ын тулд өдөр бүр хэрэгжүүлэх чухал үйлүүд юм.

“Хэлбэр”-ийг хэвшил болгосон байх юм бол сэтгэл үймэрсэн ч гэсэн эргээд энэрэнгүй нинжин сэтгэлээ олж авах нь хурдан байна. Энэ утгаараа “хэлбэр” нь энэрэнгүй нинжин сэтгэлтэй болох “уран арга” ч гэж хэлж болно.



### “Хэлбэр”-ийг хэвшүүлэх нь хувиа бодох сэтгэлээс ангижирах үйл

Энэрэнгүй нинжин сэтгэлээс өдөр тутмын амьдралын “хэлбэр” буюу үйл хөдлөл бий болдог гэж үзвэл тэр хэлбэр нь бүгд ижилхэн байх албагүй. Дэлхий дээр яг адилхан хүн гэж байхгүй болохоор тухайн хүний зан чанараас шалтгаалаад энэрэнгүй нинжин сэтгэлээс гарах үйл хөдлөл нь ондоо байх нь ойлгомжтой. Мөн судар унших ба сэиза /өвдөгөө нугалж суух Японы уламжлалт суулт/ чухал гэж хэлсэн ч гэсэн ингэж сууж чадахгүй хүн байж болно. Тэгвэл тэр хүн “хэлбэр”-ийг баримтлахгүй байна уу гэвэл үгүй юм. Буддын сургаалд “нэг нт олныг илэрхийлж, олон нь нэгийг илэрхийлдэг” гэсэн сургаал байдаг. Тиймээс үйл хөдлөл олон янз байсан ч гэсэн түүний цаана орших сэтгэл, хүсэл эрмэлзлэлийг мартахгүй байх чухал.

Хүнээсээ шалтгаалаад олон янзын “хэлбэр” байж болох ч, дураараа зохиосон “хэлбэр”-ийг зөв “хэлбэр” гэж хэлэх аргагүй. “Хэлбэр” гэдэг нь харин ч эсрэгээр “хүссэнээрээ байх” сэтгэлийг дарахын тулд байдаг гэж хэлж болох юм.

Ямар нэгэн шалтгаанаар гэр бүл болон хэн нэгэн танилынхаа царайг харж, яриаг нь сонсохыг хүсэхгүй үе байдаг. Тэр сэтгэлээрээ тухайн хүнтэй эвгүй харилцах юм бол хүйтэн хөндий байдал үүснэ. Харин алга хавсран мөргөж, “өглөөний мэнд” гэж мэндлэх “хэлбэр”-ийг хэвшүүлсэн байх юм бол “харахыг хүсэхгүй байна” гэсэн хувиа бодсон сэтгэл аяндаа алга болно. Тиймээс ингэж мэндлэх нь эргээд эв түнжинтэй болох эхний алхам болох ба мэндэлсэн хүний сэтгэл ч гэсэн мэндлээгүйгээсээ илүү уужуу тайван байна.

“Хэлбэрийг баримтлах чухал” гэхээр өөрчлөлт, шинэчлэл байхгүй мэт санагдаж магадгүй. Гэвч хувийн хүслээ нэгдүгээрт тавих гээд байдаг хүмүүс бидний хувьд үг дуугүй “хэлбэр”-ийг хэрэгжүүлж сурсанаар хувиа бодсон сэтгэлээсээ амархан ангижирдаг билээ.

Манай байгууллагын хооза, судар уншлага, “эхлээд бусад хүмүүс” гэсэн үйлүүд ч гэсэн бурхантай адил энэрэнгүй нигүүлсэнгүй хүн болох чухал “хэлбэр” бөгөөд байгууллагын түүхтэй салшгүй холбоотой “аз жаргалд хүрэх үйл” юм.

“Косей” сэтгүүл 12-р сарын дугаараас



# The 7 Parables of the Lotus Sutra

## Шатаж буй байшингийн үлгэр

Оройн Дээд Цагаан  
Лянхуа Судар  
«Үлгэрлэл 3-р бүлэг»

Нэгэн баян хүн том орд харшдаа хүүхдүүд болон зарц шивэгчинтэйгээ олуулаа амьдарлаг байжээ. Гэхдээ орд харш нь эвдэрч хуучирсан байв. Нэг өдөр байшинд гэнэт гал гарах боловч хүүхдүүд нь мэдэлгүй тоглосоор байв. Гадагш гарсан байсан аав нь яаран гэртээ ирж, чанга дуугаар хүүхдүүдэд анхааруулавч тоглоомондоо улайрсан хүүхдүүд нь сонсохгүй байжээ.



Аав нь “хүүхдүүдээ ямар нэг ширээ шиг зүйл дээр суулгаад гадагш гаргадаг юм билүү” гэж бодож үзэв. Гэвч “замдаа хэн нэг нь уначихаж магадгүй” гээд болив. Тэгээд хүүхдүүдэд галны аюулыг хэлж, анзааруулахыг оролдсон боловч хүүхдүүд нь харах ч үгүй байв. Эцэст нь “уран арга хэрэглэж хүүхдүүдээ аврахаас өөр арга алга” хэмээн бодож хүүхдүүдийнхээ дуртай хонь, буга, үхэр тэргийг өгнө шүү хэмээн хэлэв.

Хүүхдүүд нь шатаж буй байшингийн ганцхан байдаг давчуу хаалгаар өөрсдөө гүйн гарч ирэв. Аав нь хүүхдүүдээ амьд мэнд гарч ирсэнд туйлын их баярлав. Хүүхдүүд нь гарч ирээд “сая хэлсэн хонь, буга, үхэр тэргээ өгөөч” гэж гуйв. Харин аав нь түүнээс бүр ч том гайхамшигтай цагаан үхэр тэргийг бүгдэд нь ижилхэн өгчээ.



## Тайлбар:

Энэ үлгэрт гарч буй аав нь Бурхан, хүүхдүүд нь хүмүүс бид юм. Эвдэрч хуучирсан байшингаар бидний амьдарч буй дэлхий ертөнцийн аюулыг илэрхийлжээ. Гал нь амьдралын зовлонг илэрхийлж байгаа ба зовлон хэзээ нэгэн цагт гэнэт гарч ирдэг боловч бид түүнийг анзаарах сөхөөгүй хүсэл шуналдаа автсан байдаг байна.

Бурхан биднийг аврахын төлөө чин сэтгэлээсээ хүсэн залбирч байдаг. Зовлонгоос ангижирахын тулд бид өөрсдөө Бурханы хүслийг ухаарч, өөрсдийн хүчээр хаалгаар гарахгүй бол болохгүй. Бурхан ямар нэгэн ширээ шиг зүйл дээр суулгаад гаръя гэсэн ч бид зовлонгоо ухаараагүйн улмаас авралын гараас нь барьж чадалгүй үлдчихэж магадгүй. Тиймээс Бурхан эхлээд зовлонг нь ухааруулъя хэмээн байдаг чадлаараа анхааруулах боловч бид бас л анзаардаггүй. Бурханыг нүднийхээ булангаар харах боловч чин сэтгэлээсээ сургаалыг нь сонсьё гэж боддоггүй байна.

Ингээд Бурхан сүүлчийн аргаа ашиглан хонь, буга, үхэр тэргийг өгье гэдэг. Энэ нь “өөртөө таарсан сургаалаас эхэлж сурахад болно” гэсэн утгатай ба ингэснээр бид анх сургаалыг сонсьё гэж боддог.

Шатаж буй байшингаас өөрийн хүчээр гүйн гарсан гэдэг нь бид өөрсдөө бурханы үйлийг хийсэн гэсэн үг. Гэвч бид ийнхүү хэдийн аз жаргалтай болсоноо ухаарахгүй, хүсэж байсан тэргээ өгөөч хэмээн гүйн бодит амьдралын хүслээ биелүүлэхийн төлөө л байдаг байна. Улмаар чин сэтгэлээсээ Бурханд залбирч хүслээ хэлснээр Бурхан бодож ч байгаагүй том цагаан үхэр тэрэг буюу дээдийн гэгээрлийг бүгдэд нь ижилхэн өгдөг. Өөрөөр хэлбэл өөртөө таарсан бурханы үйлийг үргэлж хэрэгжүүлснээр бурханы гэгээрлийг олж чадна гэсэн үг юм.

Бурхан үргэлж биднийг өөрийн хайртай хүүхдүүд хэмээн бодож санаа зовж, зовлонгоос ангижруулахын төлөө байдаг. Энэ дэлхий ертөнц бол үнэхээрийн зовлонгоор зовлонгоор дүүрэн шатаж буй байшин мэт зүйл. Гэвч Бурхан тийшээ өөрөө ирж, бидэнд бурханы гэгээрлийг олох зам мөрийг зааж өгдөг билээ.





### 6 жил үнэхээр их баярлалаа

Удирдах төвийн хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний шийдвэрийн улмаас би олон улсын хэлтсийн даргын үүргээс солигдох боллоо. 6 жилийн турш тусалж дэмжиж байсан та бүхэнд туйлийн их талархаж байна. Энэ 6 жил миний хувьд өдөр бүр аж жаргалаар дүүрэн байсан. Ялангуяа дэлхийн өнцөг булан бүрт гишүүдтэй уулзаж, сургаалтай учирсны баяр хөөр хуваалцаж байсан тэр сэтгэл хөдлөлийг мартахын аргагүй.

Ирэх жилээс Өмнөд Азийн сургаал дэлгэрүүлэх хэсгийн дарга, Бангкок салбарын тэргүүнээр ажиллахаар болсон. РКК байгууллагын сургаал бол үнэхээрийн гайхалтай сайхан сургаал. Энэ гайхалтай сургаалыг би шинэ газарт, илүү олон хүнд дамжуулах гэж байгаадаа баяртай байна.

Олон улсын хэлтсийн шинэ даргыг Саитоо Коичи гэдэг ба мундаг сургаал дэлгэрүүлэгч хүн. Бид хоёр дотны найзууд. Тэрээр Нью-Йорк салбарын тэргүүнээс авахуулаад 20 гаруй жил гадаад, дотоодын салбарын тэргүүнээр ажиллаж байсан туршлагатай. Мөн бие нь ч, сэтгэл зүрх нь ч агуу хүн. Түүний удирдлагаар сургаал ном дэлхий дахинд улам өргөн дэлгэр түгнэ гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэн сайн сууж байгаарай. Түүнчлэн сургаалтай учирсан баяр хөөрөө нэг ч гэсэн илүү хүнд дамжуулцгаая. 6 жил үнэхээр их баярлалаа.



Саитоо дарга (зүүн) ба Мизутани дарга (баруун)



## Сайн байцгаана уу. Та бүхэнтэй ажиллах болсондоо баяртай байна

Намайг Саитоо Коичи гэдэг. 12 сарын 1-ээс Олон улсын хэлтсийн даргаар ажиллах болсон. Харин хүү Саитоо Юүсүкэ Олон улсын хэлтсээс өөр хэлтэс рүү шилжихээр болж байгаа. Өнөөдрийг хүртэл тусалж дэмжиж байсанд талархал илэрхийлье.

Би 16 жил шашны хамтын ажиллагааны чиглэлээр ажиллаж, дараа нь Шибата, Нью-Йорк, Сүмида, Хирошима салбарын тэргүүнээр ажиллаж байсан. Тэргүүнээр ажилласан 19 жилийн турш дайн, террорист үйл ажиллагааны хөлд үрэгдсэн хүмүүсийн

төлөө залбирч, энх тайвны чухлыг үргэлж санаж явдаг байсан.


Цаашид Олон улсын хэлтсийн даргын хувиар Үүсгэн байгуулагчийн бидэнд захиж үлдээсэн “РКК байгууллага Цагаан Лянхуа Сударыг дэлхийд түгээх болно” гэсэн үгийг санаж, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллах болно.

Ирээдүйд хэрэгтэй боловсон хүчнийг бэлдэж, дэлхий дахинд бодисадваг бий болгох гэсэн байгууллагын зорилтын дагуу хамтдаа алхацгаая.

Товч намтар:

Саитоо Коичи нь 1957 онд Токио хотод төрсөн. РКК байгууллагын Гакурин сургуулийг төгссөнийхөө дараа Дэлхийн шашны энх тайвны чуулганы Япон дахь төв салбарт ажиллаж, Удирдах төвийн шашны хамтын ажиллагаа, энх тайвны үйл ажиллагааны хэлтэст 12 жил ажилласан. Энэ хугацаандаа Германы Франкфурт хотод төвтэй Олон улсын чөлөөт шашны холбоонд ажиллаж байсан туршлагатай. 1998 оноос дотоод болон гадаад салбарын тэргүүн, бүсийн даргаар ажиллаж байсан ба 2017 оны 12 сарын 1-ээс Олон улсын хэлтсийн даргаар ажиллахаар болоод байгаа билээ.

Олон улсын хэлтсийн дарга  
Саитоо Коичи



❀ RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES ❀



We welcome comments on our e-newsletter Living the Lotus.  
Please send us your comments to the following e-mail address.  
E-mail: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

# Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

# 2017

## **Rissho Kosei-kai International**

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel:* 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

## **Rissho Kosei-kai International of North America (RKINA)**

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.  
*Tel:* 1-323-262-4430 *Fax:* 1-323-262-4437  
*e-mail:* info@rkina.org <http://www.rkina.org>

## **Branch under RKINA**

### **Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center**

28621 Pacific Highway South, Federal Way,  
WA 98003 U.S.A.  
*Tel:* 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261  
*e-mail:* rkseattlewashington@gmail.com  
<http://buddhistlearningcenter.org/>

### **Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio**

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.  
P.O. Box 692148, San Antonio, TX 78269, USA  
*Tel:* 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745  
*e-mail:* dharmasanantonio@gmail.com  
<http://www.rkina.org/sanantonio.html>

### **Rissho Kosei-kai of Tampa Bay**

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.  
*Tel:* (727) 560-2927 *e-mail:* rktampabay@yahoo.com  
<http://www.buddhismtampabay.org/>

### **Rissho Kosei-kai of Vancouver**

## **Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii**

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.  
*Tel:* 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633  
*e-mail:* info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

### **Rissho Kosei-kai Maui Dharma Center**

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.  
*Tel:* 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4625

### **Rissho Kosei-kai Kona Dharma Center**

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,  
HI 96740 U.S.A.  
*Tel:* 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

## **Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles**

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.  
*Tel:* 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567  
*e-mail:* rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

### **Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**  
**Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**  
**Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**  
**Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## **Rissho Kosei-kai of San Francisco**

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.  
*Tel:* 1-650-359-6951 *Fax:* 1-650-359-6437  
*e-mail:* info@rksf.org <http://www.rksf.org>

**Rissho Kosei-kai of Sacramento**  
**Rissho Kosei-kai of San Jose**

## **Rissho Kosei-kai of New York**

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.  
*Tel:* 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499  
*e-mail:* rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

### **Rissho Kosei-kai of Chicago**

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.  
*Tel:* 1-773-842-5654 *e-mail:* murakami4838@aol.com  
<http://home.earthlink.net/~rkchi/>

### **Rissho Kosei-kai of Fort Myers**

<http://www.rkftmyersbuddhism.org/>

## **Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma**

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.  
*Tel & Fax:* 1-405-943-5030  
*e-mail:* rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

### **Rissho Kosei-kai, Dharma Center of Denver**

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.  
*Tel:* 1-303-446-0792

### **Rissho Kosei-kai Dharma Center of Dayton**

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.  
<http://www.rkina-dayton.com/>

## **Rissho Kosei-kai do Brasil**

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,  
CEP 04116-060 Brasil  
*Tel:* 55-11-5549-4446 / 55-11-5573-8377  
*Fax:* 55-11-5549-4304  
*e-mail:* rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

### **Rissho Kosei-kai de Mogi das Cruzes**

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,  
CEP 08730-000 Brasil  
*Tel:* 55-11-5549-4446/55-11-5573-8377

## **Rissho Kosei-kai of Taipei**

4F, No. 10 Hengyang Road, Zhongzheng District,  
Taipei City 100 Taiwan  
*Tel:* 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433  
<http://kosei-kai.blogspot.com/>

### **Rissho Kosei-kai of Taichung**

## **Rissho Kosei-kai of Tainan**

No. 45, Chongming 23rd Street, East District,  
Tainan City 701 Taiwan  
*Tel:* 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

### **Rissho Kosei-kai of Pingtung**

## **Korean Rissho Kosei-kai**

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
*Tel:* 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696  
*e-mail:* krkk1125@hotmail.com

### **Korean Rissho Kosei-kai of Busan**

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
*Tel:* 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

#### **Branches under the Headquarters**

##### **Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,  
North Point, Hong Kong, Republic of China

##### **Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia  
*Tel:* 976-70006960    *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

##### **Rissho Kosei-kai of Sakhalin**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk  
693005, Russian Federation  
*Tel & Fax:* 7-4242-77-05-14

##### **Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia  
*Tel & Fax :* 39-06-48913949    *e-mail:* roma@rk-euro.org

##### **Rissho Kosei-kai of the UK**

##### **Rissho Kosei-kai of Venezia**

##### **Rissho Kosei-kai of Paris**

#### **International Buddhist Congregation (IBC)**

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel:* 81-3-5341-1230    *Fax:* 81-3-5341-1224  
*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp    <http://www.ibc-rk.org/>

#### **Rissho Kosei-kai of South Asia Division**

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel:* 81-3-5341-1124    *Fax:* 81-3-5341-1224

#### **Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel:* 66-2-716-8141    *Fax:* 66-2-716-8218  
*e-mail:* thairissho@csloxinfo.com

#### **Branches under the South Asia Division**

##### **Rissho Kosei-kai of Central Delhi**

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,  
110060, India

##### **Rissho Kosei-kai of West Delhi**

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka, New Delhi 110075, India

##### **Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

##### **Rissho Kosei-kai of Kolkata North**

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,  
West Bengal, India

##### **Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center**

Ambedkar Nagar, West Police Line Road  
Rumpur, Gaya-823001, Bihar, India

##### **Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,  
Kathmandu, Nepal

##### **Rissho Kosei-kai of Phnom Penh**

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,  
Phnom Penh, Cambodia

##### **Rissho Kosei-kai of Patna Dharma Center**

##### **Rissho Kosei-kai of Singapore**

#### **Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel:* 66-2-716-8141    *Fax:* 66-2-716-8218    *e-mail:* info.thairissho@gmail.com

#### **Rissho Kosei-kai of Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel & Fax:* 880-31-626575

##### **Rissho Kosei-kai of Dhaka**

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,  
Dhaka Cant.-1206, Bangladesh  
*Tel:* 880-2-8413855

##### **Rissho Kosei-kai of Mayani**

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,  
District: Chittagong, Bangladesh

##### **Rissho Kosei-kai of Patiya**

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

##### **Rissho Kosei-kai of Domdama**

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

##### **Rissho Kosei-kai of Cox's Bazar**

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

##### **Rissho Kosei-kai of Satbaria**

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

##### **Rissho Kosei-kai of Laksham**

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,  
Bangladesh

##### **Rissho Kosei-kai of Raozan**

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

##### **Rissho Kosei-kai of Chendirpuni**

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

##### **Rissho Kosei-kai of Ramu**

#### **Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
*Tel:* 94-11-2982406    *Fax:* 94-11-2982405

##### **Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

##### **Rissho Kosei-kai of Polonnaruwa**

#### **Other Groups**

##### **Rissho Kosei-kai Friends in Shanghai**